



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/284

Улаанбаатар хот

Барилга угсралтын ажлын гэрээ сунгаж,  
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, Үндэсний аудитын газрын 2015 оны албан шаардлага, 2016 оны 1/28 актыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн багцанд батлагдсан XVII.1.1.1 Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ угсралтын ажлын гүйцэтгэгч "Энигма" ХХК-ний хүсэлтийн дагуу бодит гүйцэтгэлийг дахин 2016 оны 9 дүгээр сарын 01-ний дотор гаргуулсугай.

2. Үүнтэй холбогдуулан Үндэсний аудитын газраас тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдээгүй гэж тавигдсан 2,269,955,724 /хоёр тэрбум хоёр зуун жаран есөн сая есөн зуун тавин таван мянга долоон зуун хорин дөрвөн/ төгрөгийн төлбөрийн асуудлыг Үндэсний аудитын газарт дахин тавьж шийдвэрлүүлэхийг Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Баярсайхан/-д үүрэг болгосугай.

3. Гэрээг сунган, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д даалгасугай.

САЙД



С.ЛАМБАА

081050